



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“НОМИН ДААТГАЛ” ХХК-НИЙ ЗАХИРАЛ ТАНАА

Бид 2014 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, мөн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол гол бодлогууд ба бусад нэмэлт тайлбар мэдээллүүдийг багтаасан “НОМИН ДААТГАЛ” ХХК-ний санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлага

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан эсвэл алдааны улмаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлага мөн багтдаг.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол эдгээр санхүүгийн тайлангуудад аудитын дүгнэлт өгөх явдал юм. Бид өөрсдийн аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаанаас ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлтүүд ба тодруулгуудын талаар аудитын нотолгоог олж авахын тулд аудитын горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгосон горимууд нь аудитор залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг төлөвлөхийн тулд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

Түүнчлэн аудитын ажилд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудын үндэслэлтэй байдал болон санхүүгийн тайлангийн толилуулгыг ерөнхийд нь үнэлж үзэх ажлууд багтдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоонууд нь аудитын дүгнэлт өгөхөд хангалттай ба зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд 2014 оны 12 дугаар сарын 31-ээрх “НОМИН ДААТГАЛ” ХХК-ний санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

ЗАХИРАЛ

Г.ДӨЛГЭРЦЭЦЭГ

2015 ОНЫ 03 ДУГААР САРЫН 03

МОНГОЛ УЛС

УЛААНБААТАР ХОТ

